

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын Гүйцэтгэлийн
аудитын газар

Захирал

Д.Ганбилэг

Аудитын менежер

Х.Баярмаа

Ахлах аудитор

С.Сэрчхорол

Шинжээч *Д.Баттулга*

Б.Болормаа

2010 оны 12 дугаар сар

**Уг тайланг ҮАГ-ын
вэб сайт-аас үзнэ үү:**

www.mnao.mn

*Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
261885, 263755 дугаарын утас,
323266 дугаарын
факсаар харилцана уу.*

ХАЯГ:

*Үндэсний аудитын газар
Засгийн газрын 4 дүгээр байр,
Бага тойруу-6, Улаанбаатар-46
Монгол Улс*

Товчилсон үгсийн жагсаалт	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Бүлэг 1 Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах ажлын үр дүн сул байна	
• Ерөнхий зүйл	4
• Олон улсын конвенци, гэрээ хэлэлцээрт нэн ховор, ховор амьтдын талаар тусгасан заалтууд манай улсад бүрэн хэрэгжихгүй байна	4
• Монгол Улсын “Улаан ном”-д бүртгэгдсэн нэн ховор, ховор амьтны ангилал “Улаан данс”-ны ангилалтай уялдахгүй байна	5
• Ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох журмыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна	6
• Ховор амьтдыг агнасны төлбөр хураамжаас ан амьтныг хамгаалахад хөрөнгө бага зарцуулжээ	8
• Нэн ховор, ховор амьтдыг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт үр дүн муутай байна	11
• Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага сул байна	13
Бүлэг 2 Нэн ховор, ховор амьтны нөөц, байршлыг тогтоох ажил эхлэлийн шатанд байна	
• Ерөнхий зүйл	15
• Нэн ховор, ховор амьтны нөөц, байршлын судалгааг хийгээгүй байна	15
• Нэн ховор, ховор амьтны талаархи мэдээллийн санг хууль, журмын дагуу бүрдүүлээгүй байна	23
• Нэн ховор, ховор амьтдыг хамгаалахад ард иргэд, ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна	25
• Дүгнэлт	26
• Холбогдох байгууллагын санал	27
• Тайлбар	30
• Зөвлөмж	31

Товчилсон үг

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
БОХТХ	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
ТХГНТХ	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
ТХГНОБТХ	Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
СС	Сангийн сайд
БОС	Байгаль орчны сайд
УМХЕГ	Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХАХҮК	Монголын ховор амьтдыг хамгаалах үндэсний комисс
МБОҮХ	Монголын байгаль орчны үндэсний холбоо
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ДЦХГЗ	Дархан цаазат хамгаалалттай газрын захиргаа
ДЦГ	Дархан цаазат газар
ТХГ	Тусгай хамгаалалттай газар
МУИС	Монгол Улсын Их Сургууль
ХМХА	Хилийн мэргэжлийн хяналтын алба
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ХХА	Хил хамгаалах алба
ТББ	Төрийн бус байгууллага
ЗД	Засаг дарга

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудитыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны санал, ҮАГ-аас Монгол Улсын Ерөнхий аудиторт 2010 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Монгол орны нэн ховор, ховор амьтны хамгаалалтын байдлыг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- БОАЖЯ-наас хэрэгжүүлж буй нэн ховор, ховор амьтдыг зохистой ашиглах, хамгаалах ажил үр дүнтэй байгаа эсэх;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас нэн ховор, ховор амьтдыг хамгаалах талаар хийж буй ажил үр дүнтэй эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад БОАЖЯ, зарим аймгийн ЗДТГ, баг, сум, БОАЖГ, ТХГНЗ, ТББ болон бусад холбогдох байгууллагуудыг түүвэрчилж хамруулав.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- БОАЖЯ-наас нэн ховор, ховор амьтныг хамгаалах талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилтийг харьцуулах;
- Олон улсын конвенци, гэрээ хэлэлцээр болон хууль тогтоомжид нэн ховор, ховор амьтдын талаар тусгасан заалтын хэрэгжилтийг шалгах;
- Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах, хяналт тавих ажилд ард иргэд, ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх боломжийг судалж үзэх;
- Ховор амьтдыг агнах талаархи хууль эрх зүйн баримт материалтай танилцах;
- Ховор амьтдыг агнасан орлого төсөвт бүрэн төвлөрсөн эсэхийг тулган баталгаажуулах;
- Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах талаар зарцуулсан хөрөнгийн судалгааг гаргуулж, дүн шинжилгээ хийх;
- Нэн ховор, ховор амьтныг хууль бусаар агнасан зөрчлийн талаархи судалгааг Эрүүгийн цагдаагийн газар, Мөрдөн байцаах газраас гаргуулж дүгнэх;

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1


Нэн ховор, ховор амьтдыг хамгаалах ажлын үр дүн сул байна

Ерөнхий зүйл

1.1 БОАЖЯ-ны үйл ажиллагааны нэг хэсэг нь нэн ховор, ховор амьтдыг хамгаалах, нөөцийг тогтоох, зохистой ашиглах, нөхөн сэргээх, өсгөн үржүүлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг хангуулах, хяналтыг сайжруулах, төсөл, хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгддэг.


Олон улсын конвенци, гэрээ хэлэлцээрт нэн ховор, ховор амьтдын талаар тусгасан заалтууд манай улсад бүрэн хэрэгжихгүй байна

1.2 Монгол Улс 1993 онд Биологийн төрөл зүйлийн конвенци (CBD), 1996 онд “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай” конвенци (CITES), 1997 онд Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенци (RAMSAR), 1999 онд “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай” Боннын конвенци (CMS), 2002 онд “Халимны менежментийн тухай конвенци”-д тус тус нэгдэн орсон.



1.3 БОАЖС-ын 2009 оны 155, 310 дугаар тушаалаар дээрх олон улсын конвенцийн хүрээнд Монгол Улсын талаас хэрэгжүүлэх асуудлыг зохион байгуулах үндэсний зохицуулагч, захирал, түүний ажлын хэсгийг томилон ажиллуулж холбогдох арга хэмжээг авч ирсэн байна. Үүнд:

- Биологийн төрөл зүйлийн конвенциар хүлээсэн үүргийн дагуу нийт нутаг дэвсгэрийн 14.4 хувь буюу 22.5 сая га талбай бүхий 65 газрыг улсын тусгай хамгаалалтад авсан;
- Экологийн талаар баримтлах бодлого, биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр, Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр, Идлэг шонхор хамгаалах, Аргаль хамгаалах, Ирвэс хамгаалах, Агнуурын загас хамгаалах, Бөхөн хамгаалах үндэсний хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна.



1.4 НҮБ-ын байгаль орчны суурь гурван конвенцийн нэг болох “Биологийн төрөл зүйлийн конвенци”-тэй холбогдуулан биологийн төрөл зүйлийн асуудлыг БОАЖЯ-нд хоёр мэргэжилтэн хариуцан гүйцэтгэж байгаа нь тухайн конвенцийг хэрэгжүүлэхэд учир дутагдалтай байна.

1.5 Конвенцийн хүрээнд хэрэгжүүлж байгаа “Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр” хэрэгжиж эхэлснээс хойш 13 жил өнгөрч байгаа ч хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат тодорхойгүй, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй байна.

1.6 Тус конвенцийн 1, 2 дугаар хавсралтад 14 зүйлийн хөхтөн, 71 зүйлийн шувуу, 8 зүйл ургамал, 2 зүйл загас, нэг зүйл шавьж, нэг зүйл мөлхөгч бүртгэгджээ.

1.7 Дээрх конвенцийн Монголын талын удирдан зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжоогүй, гааль, хилийн хяналт, МХЕГ-тай хамтарсан шалгалт, мэдээлэл солилцох ажил хийгдээгүй, холбогдох хууль тогтоомжийн дагуу хураан авсан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг борлуулах, устгах ажлыг зохион байгуулах, конвенцийн талаар зохиож байгаа ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажил дутмаг, хууль бус худалдааны тухай мэдээллийн санг үүсгээгүй байна.

1.8 Шинжлэх ухааны зөвлөлд конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамлын нөөц, амьдрах орчны байдал, тоо толгойн хэлбэлзлийн судалгаа алга байна.

1.9 “Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай” конвенцийн хүрээнд Тэрхийн цагаан нуур, Өгий нуур, Нууруудын хөндийн бүлэг нуурууд, Хар ус нуурын БЦГ, Айраг, Ачит, Увс, Буйр, Ганга нуур, Хурх-Хүйтний голын хөндийн нуур зэрэг 1.4 сая га талбай бүхий 11 нууруудыг RAMSAR-ийн жагсаалтад, “Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлийг хамгаалах тухай” Боннын конвенцид бөхөн, цагаан тогоруу, жороо тоодог зэрэг амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх талаархи санамж бичиг байгуулан, хавсралтад хавтгай, хар сүүлтий, хулан зэрэг нүүдлийн хөхтөн амьтад, 5 зүйл шувууг нэмж тус тус оруулсан байна.


1.10 Монгол Улс “Халимны менежментийн тухай” конвенцид нэгдэн орсон боловч хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь тодорхойгүй, төлөвлөсөн ажил алга байна.

1.11 Олон улсын конвенциудын Удирдан зохицуулах зөвлөл, шинжлэх ухааны зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Монгол Улсын “Улаан ном”-д бүртгэгдсэн нэн ховор, ховор амьтны ангилал “Улаан данс”-ны ангилалтай уялдахгүй байна

1.12 1948 оноос Байгаль хамгаалах олон улсын холбоо устаж, ховордож байгаа ургамал, амьтны зүйлийг бүртгэх комисс байгуулж, 1969 онд “Дэлхийн улаан ном”-ыг буй болгосноор манай орны амьтдаас тахь, хулан, хавтгай, япон тогоруу зэрэг 4 зүйлийн амьтан бүртгэгдсэн байна.

1.13 Манай оронд 1985 онд 23 зүйлийн хөхтөн, 19 зүйлийн шувуу, 6 зүйлийн хоёр нутагтан, 2 зүйлийн загас, 86 зүйлийн ургамлын зүйлийг багтаасан “Улаан ном”-ыг буй болгож 1987, 1997 онд хэвлэн гаргажээ.



1.14 Амьтны аймгийн тухай хуулийн 6.2-т: “Нэн ховор, ховор амьтныг олон улсын болон Монгол Улсын “Улаан ном”, бусад холбогдох гэрээ, конвенцийн хавсралтад бүртгэх” гэж заасны дагуу нэн тэргүүнд хамгаалах шаардлагатай ховор 100 зүйл амьтанг оруулсан байна. Үүнд: хөхтөн 30, шувуу 30, хэвлээр явагчид 5, хоёр нутагтан 4, загас 12, шавьж 19 зүйл амьтанг бүртгэжээ.

1.15 Монгол Улсын “Улаан ном”-ыг ан амьтан устгах, ховордох, нөөцгүй болсныг хамгаалах, таниулах, тухайн амьтны биологийн төрөл зүйлийн онцлог, тархац, нөөцийн талаархи судалгаа шинжилгээний ажлыг мэдээлэх зорилгоор гаргасан боловч энэ номны олдоц улсын хэмжээнд хомс, ховор амьтдын талаарх мэдээлэл дутмаг байна.

1.16 “Улаан ном” нь зөвхөн танин мэдэхүй, эрдэм шинжилгээний бүтээл гэхээс илүүтэйгээр нэн ховор, ховор амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

1.17 Дэлхийн “Улаан данс”-нд ан амьтныг 10 ангилдаг ба манай улсын нэн ховор амьтан нь тухайн номны “устаж байгаа”, “устаж болзошгүй”, “эмзэг”, “ховордож болзошгүй” гэсэн ангилалд хамаардаг бөгөөд харин “устсан”, байгальд устсан”, “бүс нутгийн хэмжээнд устсан” гэсэн ангиллыг “Улаан ном”-д бүртгэдэггүй байна.

1.18 Мөн “Улаан данс”-нд байгаа “анхааралд өртөхөөргүй, “мэдээлэл дутмаг” “үнэлэх боломжгүй” ангиллууд нь манай орны “элбэг” ан амьтан гэсэн ангилалтай нийцэж байгаа учраас “Улаан ном”-д бүртгэгдээгүй. Иймд нэн ховор, ховор амьтдын ангилал зүйн статус, нэршлийг олон улсын хэмжээнд баримталж буй жишгийн дагуу нэг мөр болгон шинэчлэн тогтоох шаардлагатай байна.

Ховор амьтныг агнах, барих тусгай зөвшөөрөл олгох журмыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна

1.19 Ан агнуурын тухай хуулийн 6.2 дугаар зүйлд агнуурын амьтныг агнах зориулалтаар нь үйлдвэрлэлийн, ахуйн, тусгай гэж 3 ангилжээ.

1.20 Дээрх хуульд заасны дагуу ***тусгай*** зориулалтаар агнах ан амьтны тоо, хэмжээг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосноор Засгийн газар тогтоодог байна.

1.21 Засгийн газраас батлагдсан агнуурын тоо хэмжээнд багтаан БОС-ын (хуучин нэрээр) 2008 оны 79 дүгээр тушаалаар “Ан амьтан агнах, барих зөвшөөрөл олгох журам”-д заасан шалгуурыг хангасан аж ахуйн нэгжид ховор ан амьтныг агнуулах зөвшөөрөл олгох ёстой.

1.22 Гэвч 2008-2010 онд ан амьтан агнах тусгай зөвшөөрлийг журамд заасан шалгуурыг хангаагүй доорхи аж ахуйн нэгж, байгууллагуудад олгосон байна.

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Ангийн төрөл, тоо		
			2008	2009	2010
1	МХАХҮК	Амьтан хамгаалал	тэх 1		
2	"Амайзе"ХХК	Архитектор, инженер	тэх 1		
3	"Санни Гоби тур" ХХК	Гадаад худалдаа	угалз 1	тэх 1	
4	"Зэрэглээ" ХХК	Бэлэг дурсгал, гадаад худалдаа	угалз 2, тэх 10	угалз 1, тэх 4	угалз 2, тэх 6
5	"Сайхан сэтгэл"ХХК	Протезийн үйлдвэр	угалз 1, тэх 1		тэх 1
6	"4x4 Партс"ХХК	Автомашин засвар, сэлбэг	угалз 2, тэх 2	угалз 2, тэх 6	
7	"Аанар" ХХК	Гадаад худалдаа	угалз 2, тэх 10	угалз 2, тэх 4	угалз 1, тэх 2
8	"Адоре"ХХК	тодорхой бус	угалз 2, тэх 3		
9	"Нара ба Мара	Гадаад худалдаа	угалз 1		
10	"Канат хаан" ХХК	тодорхой бус	угалз 1	угалз 1	
11	"Байгаль гоби экспресс"ХХК	тодорхой бус	угалз 2, тэх 3		
12	"Тенгри групп"	тодорхой бус	угалз 2, тэх 3	угалз 2, тэх 5	
13	"ЕАС"ХХК	тодорхой бус	угалз 1	угалз 1	
14	"Их өрнөл трейд"ХХК	тодорхой бус	угалз 1, тэх 2		
15	"Даян тайж"ХХК	тодорхой бус	угалз 1, тэх 1		
16	"Ялгуусан" ХХК	тодорхой бус	угалз 1, тэх 1		
17	"Дорны сувд"ХХК	тодорхой бус	тэх 1	тэх 5	
18	"Мимоса" ХХК	тодорхой бус		тэх 5	
19	"Монголиан ВИП трейденг" ХХК	Гадаад худалдаа		угалз 1, тэх 5	
20	"Хорогдоо шарга"ХХК	Гадаад, дотоод худалдаа	тэх 1		

1.23 Тусгай зөвшөөрөл олгохдоо “Ан амьтан агнах, барих зөвшөөрөл олгох журам”-ын 17.3.1, 17.3.2¹-т заасан шалгуурыг харгалзаагүй, тухайн жилд агнуулах амьтны квот нь агнуурын нөөцөд үндэслэгдээгүй байснаас 2008 онд шалгуур хангаагүй 18 аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгож байсан бол 2010 онд яамны зүгээс энэ асуудлыг анхааран үзэж улсын төсөвт төвлөрүүлсэн ангийн төлбөр, хураамжийн орлогыг гол шалгуураа болгож ирснээр энэ тоо 3 болж буурсан байна.

1.24 Гадаадын иргэнээр ан амьтан агнуулах, бариулах аж ахуйн нэгжтэй байгуулсан гэрээнд бусад аж ахуйн нэгжийг нэмж хамруулснаар “Ан агнах, барих зөвшөөрөл олгох журам”-ын 17.5² дугаар заалтыг зөрчсөн байна.Тухайлбал,

- БОАЖС-ын 2010 оны 237 дугаар тушаалаар “Монгол Тур Ресорт” ХХК Говь-Алтай аймгийн Бугат, Хэнтий аймгийн Баянмөнх сумын ЗД-тай гадаадын анчин хүлээн авч үйлчлэх аж ахуйн гэрээ байгуулж “Жуулчин женисис” ХХК-ыг, мөн “Яагд энд тур” ХХК Ховд аймгийн Цэцэг сумын ЗД-тай байгуулсан гэрээнд “Зэрэглээ”, “Ихрэг”, “Блэк айбекс экспедишн”, “Ар монгол тревел”, “Адьяа энд алтай” ХХК-ыг тус тус нэмж оруулсан байна.
- “Зэрэглээ”ХХК Төв аймгийн Өндөрширээт сумын ЗД-тай байгуулсан гадаадын анчин хүлээн авч үйлчлэх аж ахуйн гэрээнд “Яагд энд тур”, “Хатан Эрдэнэ”, “Ихрэг” ХХК-уудыг нэмж оруулжээ.

¹ “Ан амьтан агнах, барих зөвшөөрөл олгох журам”-ын 17.3.1-т аялал, жуулчлал, эсхүл агнуурын үйл ажиллагаа 3-аас доошгүй жил эрхэлж байгаа, мэргэжлийн боловсон хүчин, материаллаг бааз, хөрөнгийн чадвартай, орон нутагт анчин хүлээн авах, бие даасан отог ажиллуулдаг байх. 17.3.2-т ан амьтны нөөц байршил, тоо толгойг судлан тогтоох зэрэг чиглэлээр орон нутагт тодорхой ажил гүйцэтгэсэн байх.

² 17.5-д Хуваарьт орсон аж ахуйн нэгж байгууллага нь нутаг дэвсгэрт нь гадаадын иргэнээр ан амьтан агнуулах, бариулах сумын Засаг даргатай гэрээ байгуулж, уг гэрээг аймгийн Засаг даргаар батлуулж, гэрээний хувийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ

1.25 “Ан амьтан агнах, барих зөвшөөрөл олгох журам”-ыг зөрчиж байгаа нь гадаадын иргэнээр ан амьтан агнуулах, бариулах гэрээний батлагдсан нэг загварын маягт байхгүй, зөрчил гаргасан аж ахуйн нэгжид хариуцлага тооцох эрх зүйн орчин дутмаг, БОАЖЯ-ны зүгээс гэрээний явц, хэрэгжилтэд тавих хяналт сул байгаатай холбоотой байна.

Ховор амьтдыг агнасны төлбөр хураамжаас ан амьтныг хамгаалахад хөрөнгө бага зарцуулжээ

1.26 Манай улс 1967 оноос эхлэн гадаадын анчдад тусгай зориулалтаар ховор амьтдыг агнах, барих, олзворын чиглэлийн аяллыг зохион байгуулж иржээ.

2006-2010 онд тусгай зориулалтаар агнуулсан, бариулсан амьтдын судалгаа

Он	Угалз	Тэх	Хар сүүлтий	Бор гөрөөс	Цагаан зээр	Чоно	Идлэг шонхор	Үнэг	Загас	Агнуурын шувуу
2006	95	290	32	44	110	17	161		200	242
2007	60	200	22	16	51	39	208	2	239	279
2008	60	200	10	17	85	15	360		148	240
2009	80	176	19	9	100	17	282		167	185
2010	47	157		12	55	17	191			202
Дүн	342	1023	83	98	401	105	1011	2	754	1148

1.27 2006-2010 онд тусгай зориулалтаар 342 угалз, 1023 тэх агнуулж, 1011 идлэг шонхорыг гадаадад гаргасан байна.

1.28 “Ан агнуурын тухай” хуулийн 8.3.³ дахь заалтыг үндэслэн ховор амьтан агнасан төлбөр хураамжийг “Жагсаалт, үнэлгээ, төлбөр, хураамжийн хувь хэмжээг батлах тухай” Засгийн газрын 2001 оны 264 дүгээр тогтоолыг баримтлан тооцож авдаг байна.

1.29 Ангийн төлбөр, хураамжийн орлогыг “Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай” хуулийн 7.3⁴-д заасны дагуу Монгол банкин дахь Сангийн яамны валютын дансанд төвлөрүүлдэг байна. Орлогыг сүүлийн таван жилийн байдлаар харуулбал,

№	Огноо	Орлогын нэр	Төсөвт төвлөрүүлсэн (сая төг)	Үүнээс	
				Төсвийн орлогод (сая төг)	Байгаль хамгаалах сан болон орон нутагт (сая төг)
1	2006	Ангийн орлого	1785,9	1355,7	430,2
		Шонхор	1548,2	1414,4	133,8
2	2007	Ангийн орлого	736,8	518	218,8
		Шонхор	1977,3	1781,7	195,6
3	2008	Ангийн орлого	462,3	219,1	243,2
		Шонхор	3075,6	2823,9	251,7
4	2009	Ангийн орлого	1658,2	1078,1	580,1
		Шонхор	3139,6	2876,2	263,4

³ 8.3.Тухайн жилд тусгай зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээг төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

⁴ ...төлбөр, хураамжийг гадаадын иргэнд ан амьтан агнуулах болон ан амьтанг амьдаар гадаад оронд гаргах аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад төлнө.

5	2010	Ангийн орлого	363,2	363,2	
		Шонхор	2874,2	2874,2	
Дүн		Ангийн орлого	5006,4	3534,1	1472,3
		Шонхор	12614,9	11770,1	844,8
Нийт дүн			17621,3	15304,2	2317,1

1.30 Ховор ан амьтан агнах төлбөр, хураамжаас сүүлийн таван жилд 17 621.3 сая төгрөг төвлөрснөөс улсын төсөвт 15 304.2 сая, Байгаль хамгаалах сан болон орон нутгийн төсөвт 2 317.1 сая төгрөг төвлөрүүлжээ.

1.31 Нийт орлогын 71.6 хувь буюу 12 614.9 сая төгрөг шонхор шувууны төлбөр, хураамжийн орлогоос бүрдсэн байна.

1.32 БОС (хуучнаар), СС-ын 1996 оны 196/328 дугаар тушаалаар батлагдсан "Гадаадын иргэнд агнуулсан болон амьдаар нь гадаад оронд гаргасан ан амьтны агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийг төлүүлэх, тэдгээрийг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт хуваарилан шилжүүлэх журам"-ын 6⁵-д заасныг зарим аж ахуйн нэгж хэрэгжүүлээгүй, ан амьтны нөөц ашигласны төлбөр, хураамжийг дутуу төлсөн, орлогын тооцоог нийлээгүй, орхигдуулсан, ангийн протокол хөтлөөгүй байна. Тухайлбал,

- 2009 онд 58 аж ахуйн нэгж, байгууллага гэрээ байгуулснаас 13 аж ахуйн нэгж буюу "Аттон-аммон" ХХК, "Санни Гоби тур" ХХК, "Монгол-Алтай трэйвел" ХХК, "Нар туг" ХХК, "Хархорин" ХХК, "4x4 Партс" ХХК, "Тенгри групп" ХХК, "Дуган хад резордс" ХХК, "Си Ти Си" ХХК, "Дорны сувд" ХХК зэрэг компаниуд гэрээгээ дүгнүүлээгүй байна.

1.33 БОХТХ-ийн 45.1⁶ болон Амьтны аймгийн тухай хуулийн 20.2⁷ -д заасны дагуу БОАЖЯ ан амьтныг хамгаалах, судалгаа шинжилгээ хийх, биотехникийн арга хэмжээнд зориулан зарцуулсан хөрөнгийг хүснэгтээр харуулбал,

Огноо	Эх үүсвэр	Зарцуулсан (сая төг)	Зардлын нэр	Ямар байгууллага гүйцэтгэсэн
2006	Төвлөрсөн арга хэмжээ	104.0	Мазаалай судалгааны ажлын байр 100.0 сая, аргал угалз нөөц үнэлгээнд 4.0 сая	МХАХҮК, Монриел ХХК
2007	Байгаль хамгаалах сан	13.5	Монгол орны идлэг шонхорын нөөцийн судалгаа, тооллогод 6.7 сая, аргаль үржүүлгийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулахад 1.7 сая, Ховд, Дундговь аймгийн аргаль, янгир, хар сүүлтий нөөцийн судалгаанд 3.1 сая, биотехникийн арга хэмжээнд 2.0 сая	Биологийн хүрээлэн, МБОҮХ, Амьтан асралт ХХК
2008	Төвлөрсөн арга хэмжээ	29.4	Монгол орны идлэг шонхорын нөөцийн судалгаа, тооллогод 10.0 сая, биотехникийн арга хэмжээнд 0.5 сая, Хар сүүлтий тархацын судалгаанд 5.8 сая, мазаалайг барих, тээвэрлэх, тэжээн дасгах судалгааны ажилд 13.0 сая	Биологийн хүрээлэн, Говьсүмбэр аймагт биотехникийн арга хэмжээнд, МХАХҮК
2009	Байгаль хамгаалах сан	25.9	Мазаалай, ирвэс хамгаалахад 21.6 сая, биотехникийн арга хэмжээнд 4.3 сая	Биологийн хүрээлэн, Шим мандал экологи судалгааны төв, Говь-Алтай, Хэнтий аймгийн БОАЖГ
2010	Байгаль хамгаалах сан	153.2	Идлэг шонхор, жигүүртэн шувуудын сүргийн бүтцийн судалгаа агнуур зохион байгуулалт, биотехникийн арга хэмжээнд, мазаалай судалгааны ажлын техник хэрэгсэл	Биологийн хүрээлэн, салбарын 19 байгууллага, МХАХҮК
Нийт дүн		326.0		

⁵ 6...тухайн жилд гадаадын иргэнд агнуулах, ан амьтны төлбөр, хураамжийн 30 хувьтай тэнцэх, хэмжээний урьдчилгааг 7 дугаар сарын 1-ний дотор тусгай зөвшөөрөл олгосон төв байгууллагын нэхэмжлэлийн дагуу төлж, жилийн эцсийн тооцоог 12 дугаар сарын 25-ны дотор хийсэн байна.

⁶ Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихад шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

⁷ Нэн ховор, ховор амьтны нөөц, тархацыг тогтоох хамгаалах ажлын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

1.34 “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хууль”-д Агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогын **50-иас доошгүй** хувийг байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээнд зарцуулахаар хуульчлан тогтоосон байна.

1.35 Гэтэл 2006-2010 онд ангийн төлбөр, хураамжаас 17 621.3 сая төгрөг төвлөрснөөс 326.0 сая төгрөгийг нэн ховор, ховор амьтны нөөцийг тогтоох, судалгаа шинжилгээ хийх болон биотехникийн арга хэмжээнд зарцуулсан нь дөнгөж 1.8 хувь болж байна.

1.36 2010 онд 153.2 сая төгрөгийг нэн ховор, ховор амьтны нөөцийг нэмэгдүүлэх, судалгаа шинжилгээ, байршлыг тогтоох, биотехникийн арга хэмжээнд зарцуулсан нь улсын төсөвт төвлөрч байгаа нь ан агнуурын орлогын 4.7 хувийг эзэлж байна.



1.37 2006-2010 онд ангийн төлбөр, хураамжаас орон нутгийн төсөвт орсон орлого болон ан амьтан хамгаалахад зарцуулсан хөрөнгийг зарим аймгаар харуулбал,

№	Аймгийн нэр	Орлого (сая төг)	Урсгал төсөвт (сая төг)	Ан амьтан, байгаль орчин хамгаалахад зарцуулсан хөрөнгө
1	Баян-Өлгий	229.9	222.1	(Буянт сум 7.8 сая төгрөгийг байгаль хамгаалах сандаа төвлөрүүлсэн)
2	Говь-Алтай	59.3	59.3	
3	Дорнод	287.8	287.8	
4	Өмнөговь	157.4	157.4	
5	Төв	459.9	459.9	
6	Увс	47.3	47.3	
Нийт дүн		1241.6	1233.8	

1.38 Судалгаанаас харахад 1 241.6 сая төгрөг орон нутгийн төсвийн орлогод төвлөрсөн боловч нэн ховор, ховор амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх талаар (7.8 сая төгрөгийг эс тооцвол) хөрөнгө мөнгө зарцуулаагүй байна.

1.39 Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 7-р зүйлийн 8-д заасны дагуу “Төлбөр, хураамжийн зохих хувийг тухайн сум, дүүргийн ИТХ-ын шийдвэрээр ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, нутагшуулах арга хэмжээнд зориулан зарцуулж болно” гэж заасан.

1.40 Дээрх хуулиар орон нутгийн төсвийн орлогод төвлөрсөн хөрөнгө хангалттай байхад нэн ховор, ховор амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх, судалгаа шинжилгээний ажилд хөрөнгө төлөвлөж, зарцуулаагүй байна.

1.41 Тусгай зориулалтын ангийн олзвороос ялангуяа шонхор шувуу, аргаль угалз, тэхийг агнаснаас жил бүр нилээд их хэмжээний орлого олж байгаа боловч тухайн амьтныг хамгаалах, тоо толгойг өсгөх, судлан шинжлэхэд наад зах нь холбогдох хууль тогтоомжид заасан хэмжээний хөрөнгө зарцуулахгүй байгаа нь тухайн зүйл амьтны нөөцийг урт хугацаанд тогтвортой ашиглах боломжгүй болох, улмаар уг амьтан устахад нөлөөлж болзошгүй байна.

Нэн ховор, ховор амьтдыг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилт үр дүн муутай байна

1.42 УИХ-аас байгаль орчныг хамгаалах, нэн ховор, ховор амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглахтай холбоотой⁸ бодлого, хууль эрх зүйн баримт бичгийг баталснаар ан амьтны төрөл зүйлийг хамгаалах, өсгөж үржүүлэх хууль, эрх зүйн орчин бүрджээ.

1.43 Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, нэн ховор, ховор амьтныг хамгаалах ажлын хүрээнд дараахь арга хэмжээг зохион байгуулсан байна.

- *Нэн ховор, ховор амьтдыг байгалийн унаган төрхөнд нь хадгалан хамгаалахад илүү ач холбогдол өгснөөр одоогоор 24.9 сая га нутаг дэвсгэрийг улсын тусгай хамгаалалттай газар нутаг эзлэх болсон;*
- *Хавтгай, мазаалай, тахь, бөхөн, молцог хандгай, зэрлэг гахай, минж зэрэг амьтдын тархац нутгийг бүрэн хамгаалалтад авсан;*
- *Ирвэс, хулан, халиу, хүдэр, аргаль, янгир зэрэг амьтдын тархац нутгийн 70 хүртэл хувийг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулан хамгаалалтад авсан;*
- *Цагаан зээр, бөхөн, тахь, минж, янгир зэрэг амьтдыг Хомын тал, Алтайн өвөр говь, Зүүн гарын говь, Хустайн нуруу, Ховд, Тэсийн гол, Богдхан уул зэрэг газруудад сэргээн нутагшуулж байна.*

1.44 “Монголын ховор амьтдыг хамгаалах үндэсний комисс” 1994 онд байгуулагдсанаар нэн ховор, ховор амьтдыг хамгаалах асуудлыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн үйл ажиллагаатай уялдуулж, төлөвлөгөө гарган ажиллаж байна.

1.45 Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Нэн ховор, ховор амьтдыг унаган байгальд нь хадгалан хамгаалах ажлыг сайжруулж, мазаалай, хавтгай, хүдэр, бөхөн, цаа буга, халиу, хар мөрний хилим зэрэг амьтдыг идээшил нутагт нь өсгөн үржүүлэх, тэдгээрийн генийн санг хамгаалах биотехнологийн ололтыг ашиглах”-аар заажээ.

1.46 Үүнийг хэрэгжүүлэх зорилгоор “Нэн ховор амьтдыг хамгаалах арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-г БОАЖС-ын 2007 оны 329 дүгээр тушаалаар баталсан боловч төлөвлөсөн ажил нь хэт ерөнхий, орон нутагт чиглэсэн тодорхой заалт байхгүй, ажлын хэрэгжилт удаашралтай байна.

⁸ Төрөөс экологийн талаар баримтлах бодлого (1997), Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2008), БОХТХ (1995, 2006, 2008), ТХГНТХ (1994), ТХГНОБТХ (1997), Ан агнуурын тухай хууль (2000, 2003), Амьтны аймгийн тухай хууль (2000), Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль (2002), Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хууль (1995), Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хууль (1997)

1.47 Монгол орны нэн ховор, ховор амьтдын хамгаалалтын байдлаас үзэхэд аймаг, орон нутаг БОХТХ-ийн 11⁹ дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал,

- *Баян-Өлгий аймагт ан амьтныг хамгаалах талаар сүүлийн 3 жилийн байдлаар 1.2 сая төгрөгийн төсөв батлагдаж 2.6 сая төгрөг зарцуулжээ. Ан амьтныг хамгаалах сан байгуулж хөрөнгө төвлөрүүлэх тогтоол гаргасан боловч хөрөнгө төвлөрөөгүй;*
- *Баянхонгор аймагт орон нутгийн төсөвт хөрөнгө тусгаагүй, хавтгай хамгаалах, өсгөн үржүүлэхтэй холбоотой зардал байхгүй, биотехникийн арга хэмжээнд 600.0-1800.0 мянган төгрөг зарцуулсан нь хангалтгүй;*
- *Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Ховд, Увс, Хөвсгөл, Завхан, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ аймгууд орон нутгийн төсөвт нэн ховор, ховор амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, судалгаа шинжилгээний ажилд хөрөнгө тусгаагүй, зарцуулаагүй;*
- *Өмнөговь аймгийн Говийн бага дархан цаазат газар, Говь гурван сайханы байгалийн цогцолборт газарт жилд дундажаар 250.0-520.0 мянган төгрөг олгосон нь ховор амьтны биотехникийн арга хэмжээнд хүрэлцээгүй;*
- *Зарим аймгийн БОАЖГ ан амьтан, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зардалд төсвийн төсөлд санал оруулаагүй;*
- *Амьтны аймгийн тухай хуулийн 6.1.8¹⁰, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12.2.6¹¹ дахь заалтыг үндэслэн зарим нэн ховор, ховор амьтны биотехникийн арга хэмжээнд Баян-Өлгий, Говьсүмбэр, Говь-Алтай, Хэнтий аймагт БОАЖЯ-наас 4.5 сая төгрөг зарцуулжээ.*

1.48 БОАЖЯ “Нэн ховор, ховор амьтан хамгаалах үндэсний хөтөлбөр” боловсруулах тендер зарлаж, гүйцэтгэгчээр “Монголын анчдын нийгэмлэг” шалгарсан боловч уг хөтөлбөрийн баримт бичгийг хугацаанд нь боловсруулж батлуулаагүй байна

1.49 Нэн ховор, ховор зарим амьтныг хамгаалах ажлын талаар яамны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний жил бүрийн төлөвлөгөөнд тусгадаг боловч уг асуудал бүрэн хэрэгжихгүй байна. Тухайлбал,

- *Нэн ховор, ховор амьтны тархац, нөөцийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан нөөцийн хэмжээг тогтоох талаар тодорхой ажил хийгдсэн боловч судалгааны дүн бүрэн гараагүй;*
- *Агнуурын бус зарим амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг шинээр тогтоон батлуулах ажил 40 хувь;*
- *Нэн ховор, ховор махчин шувуудын тархац нөөц тогтоох ажлыг зохион байгуулах ажил 50 хувьтай;*
- *Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын популяцийн хэвийн өсөлтийг хангах, хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистой ашиглалт, байгальд халгүй технологийн шийдлийг боловсруулах ажил хийгдээгүй байлаа.*

1.50 Нэн ховор, ховор амьтныг хамгаалах асуудал нь цаг зуурын бэрхшээлтэй үед биотехникийн арга хэмжээ авсан төдийнөөр бус, улсын хэмжээний нэгдсэн цар хүрээтэй арга хэмжээг зохион байгуулахыг шаардаж байна.

⁹ 11-ийн 1-д улс болон бус орон нутгийн хөгжлийн баримжааг тодорхойлох, нэн ховордсон амьтан, ургамлыг нөхөн сэргээх, өсгөн үржүүлэх, хөрс, ус, агаарыг хамгаалах болон хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах талаар судалгаа, шинжилгээний ажлыг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

¹⁰ 6.1.8. биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

¹¹ 12.2.6. байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах;

Хууль, тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага сул байна

1.51 Нэн ховор, ховор амьтдыг устаж мөхөхөд хамгийн их сөрөг нөлөө үзүүлдэг хүчин зүйл нь хууль бус ан агналт болон ан амьтны гаралтай түүхий эдийн бүтээгдэхүүний худалдаа юм.

1.52 Ан амьтанд учруулсан хохирлын нөхөн төлбөрийг Засгийн газрын 2005 оны 248 дугаар тогтоолоор батлагдсан “Ан амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ”-г үндэслэж ногдуулдаг байна.

1.53 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ан агнах, агнуурын түүхий эд бэлтгэх, боловсруулах, тээвэрлэх үйл ажиллагаанд төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагаас хяналт тавих, тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах зорилгоор “Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн гарал үүслийн тодорхойлолт олгох, хяналт тавих журам”-ыг БОАЖС-ын 2009 оны 172 дугаар тушаалаар батлуулсан боловч хэрэгжилтэд тавих хяналт сул байна.

1.54 Нэн ховор, ховор амьтныг хууль бусаар агнах, эд эрхтнийг худалдаалах, чимэглэлийн зорилгоор ашиглах байдал гарсаар байна. Тухайлбал, Ховд, Завхан, Баян-Өлгий, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий, Говь-Алтай, Төв, Хөвсгөл аймагт 12 төрлийн 206 толгой нэн ховор, ховор амьтныг хууль бусаар агнаснаас ойролцоогоор 1091.0 сая төгрөгийн хохирлыг улсад учруулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал,

2005-2010 онд гарсан зарим ховор, нэн ховор амьтны хууль бус агнуурын мэдээлэл:

№	Амьтны нэр	Амьтны төрөл	Хууль бусаар агнасан (тоо)	Хохирлын хэмжээ (сая төг)
1	Янгир	ховор	21	84.0
2	Хар сүүлтй	ховор	6	18.0
3	Бөхөн	нэн ховор	87	348.0
4	Буга	ховор	47	235.0
5	Аргаль	ховор	2	36.0
6	Зэгсний гахай	нэн ховор	4	2.7
7	Хүрэн баавгай	ховор	2	8.0
8	Ирвэс	нэн ховор	6	54.4
9	Хулан	ховор	16	102.0
10	Тул	ховор	1	200.0
11	Хойлог	ховор	13	1.9
12	Хотон	нэн ховор	1	1.0
Нийт дүн			206	1,091.0

1.55 Энэ нь Амьтны аймгийн тухай хуулийн 7.3¹², Ан агнуурын тухай хуулийн 15.1¹³ дахь заалт хэрэгжихгүй байгааг харуулж байна.

¹² “ 7.3...нэн ховор, амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс бусад түүхий эдийг худалдаалах, худалдан авахыг хориглоно ” гэсэн заалт энэн ховор амьтны гаралтай түүхий эдийн зүйлийг худалдах, худалдан авахыг хориглоно гарал үүслийн тодорхойлолтыг аваагүй ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглоно

¹³ 15.1....гарал үүслийн тодорхойлолтыг аваагүй ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглоно

1.56 Хууль тогтоомж зөрчигчдөд хариуцлага тооцох эрх зүйн орчин дутмаг, торгуулийн хэмжээ болон экологи, эдийн засгийн үнэлгээ бага, олон улсын гэрээ, хэлэлцээрээр хамгаалагдсан цагаан сахиа, саарал сахиа, нугын сахиа, хээрийн сахиа болон цасны хажир г.м зарим шувуудын үнэлгээ тогтоогдоогүй байна.

1.57 2006-2010 онд хууль бус ан агнууртай холбоотой 44 зөрчилд эрүүгийн хэрэг үүсгэн зохих хуулийн дагуу хууль зөрчигчдөд хариуцлага тооцсон байна.

БҮЛЭГ 2

Нэн ховор, ховор амьтны нөөц, байршлыг тогтоох ажил эхлэлийн шатанд байна

Ерөнхий зүйл

2.1 УИХ-аас 2000 онд “Халиун бугын үндэсний хөтөлбөр”, Засгийн газраас 2002 онд “Аргаль хонийг хамгаалах үндэсний хөтөлбөр”, 2003 онд “Монгол орны идлэг шонхорыг хамгаалах үндэсний хөтөлбөр”, 2008 онд “Агнуурын загас хамгаалах, өсгөн үржүүлэх үндэсний хөтөлбөр”, БОАЖС 2005 онд “Монгол орны цоохор ирвэс хамгаалах үндэсний хөтөлбөр”, 2007 онд “Монгол бөхөн хамгаалах үндэсний хөтөлбөр”, “Тул загас хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг тус тус баталжээ.

Нэн ховор, ховор амьтны нөөц, байршлын судалгааг бүрэн хийгээгүй байна

2.2 Нэн ховор, ховор амьтдын судалгааг улсын хэмжээнд болон хэсэгчилсэн байдлаар гаргадаг байна.

2.3 Хэсэгчилсэн байдлаар хийсэн тооллого судалгааг өмнөх оныхтой харьцуулах боломжгүй байдаг нь тухайн судалгаанд ашигласан арга зүй, техник тоног төхөөрөмж, ажлын цар хүрээ, судалгааны хамарсан талбай, боловсруулалтад ашигласан програм хангамж өөр байдагтай холбоотой байна.

Улсын хэмжээнд хийсэн нэн ховор, ховор зарим амьтны нөөцийн судалгаа:

Огноо	Аргаль хонь	Халиун буга	Баданга хүдэр	Янгир ямаа	Хулан адуу	Хар сүүлтий	Идлэг шонхор
1980	40000	140000	44000				
1986				25000 - 30000		20000-22000	
2001	13000-15000	7520			19000-20000		17000
2009	18140			24300	14051	12000	6835

2.4 Биологийн хүрээлэнгээс сүүлийн жилүүдэд хийсэн судалгаагаар мазаалай 20-25, хавтгай 350 орчим, ирвэс 1000-1200 гаруй, минж 300-325, бөхөн 4600 орчим толгой байгааг тогтоожээ. (Хавсралт № 1)

2.5 Ховор амьтны нөөц, тархац, байршил, тоо толгой, агнуурын нөөцийг судалж, экологи-эдийн засгийн үнэлгээний үндсэн дээр амьтны хэвийн өсөлт, үржлийг алдагдуулахгүйгээр агнуурыг зохион байгуулах, зарим ховордож буй амьтдыг тодорхой хугацаагаар агнах асуудлыг зогсоохгүй бол устаж үгүй болох аюул ойрхон байна.

2.6 Гэтэл өнөөгийн байдлаар ан амьтдын тооллого, судалгаа шинжилгээний ажил “Ан агнуурын тухай” хуулийн 4.4¹⁴-т заалтын хэрэгжилт хангалтгүйгээс Биологийн хүрээлэнгийн хуучин судалгааны баримжаалсан мэдээллээр нэн ховор, ховор амьтны байршил, нөөцийг тооцож байна.



2.7 Нэн ховор, ховор болон экосистемд онцгой үүрэг бүхий эдийн засгийн өндөр үр ашигтай зарим ан амьтныг хамгаалах, шинжлэн судлах, сэргээн нутагшуулах талаар зарим төслийг хэрэгжүүлж байна. Тухайлбал,

- Өмнөговь, Дорноговь, Говь-Алтай, Говь-сүмбэр, Хэнтий, Төв аймгуудад аргаль, янгир, харсүүлтий, идлэг шонхор шувууны тархац, нөөцийн судалгаа хийх;
- Хөвсгөл аймгийн Хатгал сумын Мэргэн ууланд хүдэр сэргээн нутагшуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.

2.8 Аудитаар монгол орны нэн ховор, ховор 19 амьтны хамгаалалтын байдлыг 13 аймгийн хэмжээнд шалгалаа.

Аргаль

2.9 Монгол орны Алтай, Хангайн нуруу тэдгээрийн салбар уулс, говийн бэсрэг толгодоор тархсан бөгөөд аргалийн тархацын 23.4 хувийн байршил нутгийг улсын тусгай хамгаалалтад хамруулсан байна.


2.10 Засгийн газрын 2002 оны 269 дүгээр тогтоолоор “Аргаль хонийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийг баталжээ.

2.11 УИХ-ын 2002 оны 39 дүгээр тогтоолоор аргалийн хэвийн өсөлт үржлийг хадгалах, тархац нутгийг хамгаалах зорилгоор Ховд аймгийн Мянган угалзын нурууны 11.3 мянган км² талбай бүхий нутгийг улсын тусгай хамгаалалтад авч, Хөх Сэрхийн нурууны дархан Цаазат газрын хамгаалалтын ажлыг сайжруулах, биотехникийн арга хэмжээг үр дүнтэй явуулах зорилгоор Баян-өлгий аймгийн Дэлүүн суманд шинээр хамгаалалтын захиргаа байгуулсан байна.

¹⁴ 4.4-т Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нутаг дэвмгэртээ агнуур зохион байгуулалтыг 4 жил тутамд хийлгэж, үйлдвэрлэлийн зориулалтаар агналт явуулсан тохиолдолд жил бүр тооллого хийнэ.

2.12 Ховд аймгийн Мөнххайрханы нутагт (Хойлогт, Ендорт) БОАЖС-ын 290 дүгээр тушаалаар 2007 оноос хойш аргаль агналт зохион байгуулахыг зогсоосон байна.

2.13 БОАЖЯ 2001 онд аргалийн тархац нөөцийг тогтоох ажлыг нэгдсэн арга зүй ашиглан зохион байгуулснаар 15 аймгийн 110 сумын нутагт 13.0-15.0 мянга орчим аргаль байна гэж тогтоожээ.



2.14 Харин 2009 онд улсын хэмжээнд Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Голландын Засгийн газар, Алтай Соёоны биологийн олон янз байдлыг ард иргэдийн оролцоотой хамгаалах төсөл, Германы техник хамтын ажиллагааны төслийн хүрээнд аргалийн тархац, нөөцийг судалснаар 18.1 мянга орчим байна гэж тогтоожээ.

2.15 Энэ графикаас үзэхэд: 1994 онд 60.0 мянга орчим аргаль байсан бол 2001 онд 12.0 мянга орчим болтлоо буурч, харин сүүлийн жилүүдэд тодорхой хэмжээгээр өсч байна.

Янгир

2.16 Монгол Алтай, говийн Алтай, зүүн гарын говь, Алтайн өвөр говийн уулс, Хан Хөхий, Хорьдол сарьдаг, Улаан тайгын нуруу, Дундговь, Дорноговь аймгийн цөлөрхүү хээрийн бүсийн зарим уулсаар алаг цоог тархсан байна.



байна гэж тоолжээ.

2.17 2009 онд Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Голландын Засгийн газар, Алтай Соёоны биологийн олон янз байдлыг ард иргэдийн оролцоотой хамгаалах болон Германы техник хамтын ажиллагааны төслийн хүрээнд тоолсноор янгир ямааг 36.0 мянга орчим

2.18 2009 онд нэн ховор, ховор амьтдын сүргийг хамгаалах, нөхөн сэргээх нутагшуулах эрдэм шинжилгээний ажлын хүрээнд “Богдхан ууланд янгир нутагшуулах” төсөл хэрэгжүүлжээ.

2.19 Янгирын сүргийн генийн санг бэхжүүлэх, өсөлтийг эрчимжүүлэх, янгирын тоо толгойг нэмэгдүүлэхээр Баянхонгор аймгаас 10 янгир авчирч Богдхан уулын ДЦГ-т тавихаар төлөвлөсөн боловч зохион байгуулалтгүйгээс бүрэн хэрэгжиж чадаагүй байна.

Хавтгай

2.20 Монгол Улсын баруун өмнөд хэсэгт цөөн тоогоор сүрэглэн амьдардаг бөгөөд Алтайн өвөр говийн Идрэнгийн нурууны бэлээс Шивээт уул, Хөх Төмөртийн нуруунд тархсан ба 2004 онд хийсэн Биологийн хүрээлэнгийн судалгаагаар 440-486 хавтгай байгаа гэсэн тооцоо байна.

2.21 Хавтгайг агнах асуудлыг 1930 оноос хуулиар хориглож, 1958 онд дархалж, үндсэн тархац нутгийг 1975 онд говийн их дархан газарт хамруулжээ.

2.22 “Амьтны аймгийн тухай” хуулиар хавтгайг байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац хязгаарлагдмал, устах аюулд орсон нэн ховор амьтны ангилалд оруулсан байна.

2.23 Говийн их дархан цаазат газраас хавтгайг гаршуулах зорилгоор 1987-1992 онуудад 22 ботгыг байгалийн орчноос нь салган Говь-Алтай аймгийн Баянтооройд авчирч гаршуулсан боловч уг амьтны талаархи мэдлэг хомс, удирдлага зохион байгуулалт муугаас одоогоор 13 хавтгай үлджээ.

2.24 Судалгаа шинжилгээний зориулалтаар 5 хавтгайд “сансарын дохиололт хүзүүвч” зүүж хамгаалж байна.

Мазаалай

2.25 Говь-Алтай, Баянхонгор аймгийн өмнөд хэсгийн говийн бүс нутагт 20-25 байгааг тогтоожээ.

2.26 “Мазаалай судлах, хамгаалах арга хэмжээ” төслийн хүрээнд сансрын болон радио дохиололт бүхий хүзүүвч зүүж тархалт болон байршлыг судалж байна.

2.27 Мөн БОАЖЯ мазаалайн генетикийн судалгааны зориулалтаар үсний дээж цуглуулах ажлыг Биологийн хүрээлэнтэй хамтран хийж байна.



Халиу

2.28 Дорнодын Халх голын сав, Хөвсгөлийн Шишгэдийн голын адагт 100 орчим байна гэсэн таамаг амьтан судлаачид гаргасан. 1930 оноос халиуг агнахыг хориглосон байна.

2.29 Манай орны хувьд энэ амьтныг бүрэн судалж нөөцийг тогтоож чадаагүй байна.

Хар мөрний хандгай

2.30 Халх гол түүний цутгалан, Дэгээ, Нөмрөг голын сав газарт тархжээ. 1953 оноос агнахыг хориглож, 1995 онд нэн ховор, ховор амьтан гэж хуульчилсан. Нөмрөгийн дархан газарт 73 үзэгдсэн гэж 2004 онд бүртгэсэн байна.

Хар сүүлтий

2.31 Өмнөговь, Баянхонгор, Дорноговь, Хэнтий, Говь-Алтай, Сүхбаатар аймагт нутагшдаг бөгөөд нийт сүргийн 65.8 хувь нь Өмнөговь аймагт байна.

2.32 1986 онд 22.0 мянга орчим толгой байсан бол 2009 онд хийсэн судалгаагаар нийт дэлгэц нутгийн нэг км² бүрт 0.03 бодьгал ногдох нягтшилтайгаар 11978 хар сүүлтий байх нөөц гарчээ.

Тахь

2.33 Төв аймгийн Хустайн нуруу, Говь-Алтай аймгийн Говийн их Дархан цаазат газар, Тахийн тал, Завхан аймгийн Хомын тал зэрэг газарт 2010 оны байдлаар 339 тахь байна.

2.34 Тахийг Хустайн нурууны байгалийн нөөц газар, Говийн дархан цаазат газарт сэргээн нутагшуулах зорилгоор гадаад орнуудаас авчирч, олон улсын стандартын дагуу байгальд өөрийгөө зохицуулах чадвар бүхий популяци бий болгохын тулд нийт тахийн 58 хувийг задгай бэлчээрт нутагшуулж байна.

Хулан

2.35 Зүүн гарын говь, Алтайн өвөр говь, Өмнөговь, Дорноговийн баруун хэсэг, Дундговийн өмнөд хэсэгт 14000 орчим бодьгалийн нөөцтэй байна. 1986 онд 22.0 мянга орчим байсан бол одоо 8.0 мянгаар хорогдсон байна.

2.36 БОАЖЯ, Биологийн хүрээлэнгээс 2007 онд Өмнөговь аймгийн нутагт хийсэн хэсэгчилсэн судалгаагаар 2246 хулангийн нөөц байгааг тогтоожээ.



Минж

2.37 Ховд аймгийн Булган сумын Булган голд 250-300 орчим амьдарч байгаа гэсэн мэдээ байна.

2.38 Минжийг 1930-аад оноос агнахыг хориглож, 1965 онд Ховд аймгийн Булган гол дахь тархац нутгийг дархан цаазтай газар болгож, улаан номонд оруулжээ.

2.39 Минжний тархац нутаг, нөөц, түүний үнэлгээ, өсгөн үржүүлэх хамгаалах, нягтшлыг харуулсан мэдээ судалгаа байхгүй байна.

Бөхөн



2.40 Говь-Алтай аймгийн зарим сумд, Ховд аймгийн Дарви, Манхан, Чандмань сумын нутагт 2010 оны байдлаар 5000-8000 орчим бөхөн байгааг эрдэм шинжилгээний байгууллага тогтоосон байна.

2.41 Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газраас санаачлан бөхөнг үржүүлж түүхэн тархац нутагт нь сэргээн нутагшуулах, үржүүлэхээр Швейцарийн “МАВА” сангаас 500.0 мянган еврогийн санхүүжилттэй (2007-2010 он) “Их нууруудын хотгорын бөхөн хамгаалах төсөл”-ийг хэрэгжүүлснээр бөхөнгийн нөөц нэмэгдсэн тооцоо гарчээ.

2.42 Уг төслийн хүрээнд бөхөн хамгаалагчдын нөхөрлөл байгуулах, хууль бус агнууртай тэмцэх “Ирвэс-3” багийг Говь-Алтай аймагт байгуулж, хууль бус агнуур, худалдааны талаар сургалт, сурталчилгааны 3 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, бие гүйцсэн 6 бөхөн, 40 янзаганд дохиолол бүхий хүзүүвч зүүж, мониторинг судалгаа хийсэн байна.

2.43 Мөн Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар бөхөн болон бусад ховор амьтдын тархалт, байршил, тоо толгой, бусад мэдээллийг нэгтгэх “Биосан програм”, хууль бус агнуурын зөрчилтэй холбоотой мэдээлэл цуглуулах зориулалттай “Ирвэс” хөтөлбөр хэрэгжүүлж байна.

2.44 Дээрх хөтөлбөрийн хүрээнд байгаль хамгаалагч нар сар бүрийн нэг өдөр бөхөнгийн талаар мэдээлэл цуглуулж нэгдсэн санд оруулдаг байна.

2.45 Ховд аймгийн Манхан суманд 20 орчим бөхөн байгаа нь нөхөн үржихүйн талаас “сөнөж байгаа сүрэг” гэж үздэг байна. Энэ сүргийг авч үлдэхийн тулд цус сэлбэх шаардлагатай боловч санхүүгийн байдлаас шалтгаалан арга хэмжээ авч чадахгүй байна.

Цаа буга

2.46 Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Цагаан-Уул сумын өндөр уулын тагийн бүс, задгай царам, зоо нуруугаар нутагшиж амьдардаг ба 1996 оны байдлаар 200-400 орчим цаа буга байсан бөгөөд 1953 оноос агнахыг хориглож улаан номонд оруулсан байна.

2.47 Одоогийн байдлаар байгаль хамгаалагчид зэрлэг цаа буга бараг байхгүй гэсэн боловч нутгийн цаатангуудын яриагаар 20-30 орчим үлдсэн гэжээ.

Ирвэс

2.48 Алтай, Хангайн нуруу, Алтайн өвөр говь, Хөвсгөлийн зарим уулс, Хангайн нуруунд 2005 оны байдлаар 700-1200 орчим байна гэжээ.

2.49 Ирвэс судлаачдын тооцсоноор дэлхийн популяцийн 13.0-22.0 хувь Монгол Улсад байна гэж үзжээ.

2.50 БОАЖЯ -Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран CITES-ийн хүрээнд ирвэс хамгаалах

талаар ХМХА, ГЕГ, ХХА-ны мэргэжилтнүүдэд зориулан сургалтуудыг зохион байгуулж, баримтат кино хийсэн байна.

2.51 2007 онд Өмнөговь аймгийн Тост уул, Увс аймгийн Цагаан шувуутын ДЦГ-т тус тус 40 автомат зургийн аппарат ашиглан судалгаа хийснээр, Тост уулын ирвэсний 120 гаруй зураг авч, судалгааны дүнг боловсруулснаар бие гүйцсэн 4 ирвэс, 3 гүений хамт байгааг тогтоожээ.

2.52 Өмнөговь аймгийн Гурвантэс суманд суурин судалгааны төвийг байгуулан 10 ирвэс хүзүүвчилж мэдээлэл цуглуулж байгаа бөгөөд байнгын мониторинг явуулж, идээшил нутгийг тогтоосон байна.

2.53 Монголын “Ирвэс” төв, Олон улсын ирвэс хамгаалах байгууллага (SLC), Алтай Соёны экобүсийн биологийн төрөл зүйлийг ард иргэдийн оролцоотойгоор хамгаалах төслийн санхүүжилтээр ирвэсний генетикийн шинжилгээг Австрийн Вена, АНУ-ын Техасын их сургуультай хамтран хийж гүйцэтгэжээ.

2.54 2009 онд БОАЖЯ, Монголын шим мандал, экологийн нийгэмлэгтэй хамтран Өвөрхангай аймгийн Бага Богд, Баянхонгор аймгийн Их Богд, Говь-Алтай аймгийн Далангийн нуруу, Бурханбуудай, Ховд аймгийн Жаргалант хайрханд ирвэсний тархац, нягтшилыг судлах суурин судалгаа явуулж “Ирвэс” арга зүйгээр 32 ирвэсний мөр байгааг тогтоожээ.

Халиун буга

2.55 Архангай, Булган, Баян-Өлгий, Дорнод, Завхан, Сэлэнгэ зэрэг 14 аймгийн нутаг дэвсгэрт тархсан.

2.56 Халиун бугын тархац тоо толгой, сүргийн бүтэц, нөхөн үржил, агнуурын нөөцийг тогтоох ажлыг 2004 онд Биологийн хүрээлэн, мэргэжлийн байгууллагатай хамтран хийж 102671 км² газарт 4570 орчим байна гэжээ.



2.57 УИХ-ын 2002 оны 39 дүгээр тогтоолоор бугын хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалахаар Сэлэнгэ аймгийн Шаамар суманд байгалийн цогцолбор газар байгуулжээ.

2.58 Сүхбаатар аймгийн Хар-Ямаат, Лхачинвандад зэрэг байгалийн нөөц газар, Хэнтий аймгийн Дархан уул болон Говь-Алтай аймгийн Халиун, Есөнбулаг зэрэг суманд 3.0 сая га талбай бүхий халиун бугын тархац нутгийг тусгай хамгаалалтад хамруулсан байна.

2.59 Халиун буга хамгаалах ажлын хүрээнд Төв аймгийн Мөнгөнморьт суманд бугын аж ахуйг байгуулан 16 “илий”, “Монгол буга” ХХК-д 8, “Бусо” ХХК-д 7, Богдхан ууланд 4 илий, нийт 35 бугыг тэжээврээр өсгөж үржүүлж байна.

2.60 Халиун бугын тархац, байршил хумигдаж, тоо толгой эрс ховордсонтой холбогдуулан популяцийн нас хүйсний харьцааг эрүүлжүүлэхийн тулд буга агнуулах ажлыг 2005 оноос эхлэн хориглосон байна.

Хүдэр

2.61 Хэнтий, Хөвсгөл, Хангайн уулархаг нутаг, Монгол Алтайн умард хэсгийн зарим салбар уулсаар тархсан бөгөөд 1986 оны судалгаагаар 20.0 мянга орчим байгааг тогтоожээ.



2.62 Монгол орны 1000 га газар Хэнтийд 21-35, Хангайд 6-8 толгой нягтшилтаар бүртгэгдсэн байна.

Тул

2.63 Манай орны Дархадын хотгорын Шишгэдийн сав нуур, Буйр нуур, Сэлэнгэ мөрөн, Онон, Хэрлэн, Халх голоор тархсан бөгөөд 1995 оноос агнахыг хуулиар хориглож, ховор амьтны жагсаалтад бүртгэсэн байна.

2.64 “Агнуурын загас хамгаалах, өсгөн үржүүлэх” (2008-2015 он) болон “Тул загас хамгаалах” (2007-2012 он) үндэсний хөтөлбөрүүдийг УИХ болон Байгаль орчныг хамгаалах төрийн захиргааны төв байгууллагаас батлан хэрэгжүүлж байна.

2.65 Алтай соёны экобүсийн биологийн төрөл зүйлийг ард иргэдийн оролцоотойгоор хамгаалах төслийн хүрээнд Хөвсгөл аймгийн Хогорогийн амнаас Тэнгисийн бэлчир хүртэл 24 км газарт ажиглалт хийх явцад 12 тул тэмдэглэгдсэн нь уг загасны тоо толгой цөөрснийг харуулж байна.

Алтайн хойлог

2.66 Монгол Алтай, Говь-Алтайн уулсын Баянгийн нуруу, Цамбагарав, Хангай, Хархираа, Ханхөхий зэрэг уулсын ойт хээрийн бүслүүрийн далайн түвшнээс 2700-3000 метрийн дээш 100 га газарт 15-30 бодьгалын нягтшилтай тархжээ.

Идлэг шонхор

2.67 Идлэг шонхор шувуу нь Монгол орны ойт хээр, хээр тал, говь цөлийн баянбүрд, хад цохиотой орчноор өргөн тархсан. 2010 онд хийсэн судалгаагаар 6835 орчим гэж тооцжээ.

2.68 Сүүлийн 10 жилийн хугацаанд 2699 тооны идлэг шонхорыг Арабын Эмират, Кувейт, Катар улсуудад гаргасан байна.

2.69 Олон улсын тусламж, дэмжлэг, хандиваар 1998 оноос МУИС, Монголын шувуу судлалын нийгэмлэгийн судлаачид идлэг шонхор шувууны биологи, экологи, хамгааллын чиглэлийн судалгааг хийжээ.

2.70 Дээрх судалгааны ажлын зарим үр дүнг “Монгол орны идлэг шонхорын судалгаа ба хамгаалал” бүтээлд оруулжээ. Судалгаа нь идлэг шонхорын нүүдэл, шилжилт, хөдөлгөөний хугацааг тодруулах, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна.

2.71 Нэн ховор, ховор зарим амьтны талаархи нөөцийн болон байршлын талаархи нэгдсэн судалгаа, мэдээлэл хомс, улсын хэмжээнд гаргасан тоо материал байхгүй, зөвхөн хэсэгчилсэн байдлаар судалгаа хийсэн, хамгаалах, өсгөн үржүүлэх ажлын үр дүн муу байна.

Нэн ховор, ховор амьтны талаархи мэдээллийн санг хууль, журмын дагуу бүрдүүлээгүй байна

2.72 Байгаль орчны төлөв байдал, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар бодлого боловсруулах, байгаль орчинтой холбоотой аливаа үйл ажиллагааг удирдан зохицуулахад байгаль орчны мэдээллийн сан чухал ач холбогдолтой юм.

2.73 2008 онд БОХТХ-д нэмэлт өөрчлөлт оруулж, уг хуулийн 38.1.2¹⁵ дугаар зүйлд заасны дагуу Ус, цаг уур орчны шинжилгээний газрын харъяа “Мэдээлэл, тооцооллын төв”-ийн үйл ажиллагааг өргөтгөсөн байна.

2.74 БОХТХ-ийн 35-д байгаль орчны мэдээллийн санг 20 төрлийн мэдээллээс бүрдэнэ гэж заажээ.

¹⁵ 38.1.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулна.

38.2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгаль орчны мэдээллийн төв байх бөгөөд уг төв нь улсын мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн үйлчилгээний байгууллага байна.

2.75 Гэтэл өнөөгийн байдлаар байгаль орчны салбарын мэдээллийн санд “Байгаль орчны статистик мэдээлэл”, “Химийн хорт болон аюулгүй бодис”, “Тусгай хамгаалалттай газар нутаг”, “Байгаль орчны статистик мэдээ” гэсэн 4 төрлийн мэдээлэл байна. Мэдээллийн сан бүрдээгүй нь дараахь байдлаас шалтгаалжээ. Үүнд:

- Засгийн газрын 2010 оны 85 дугаар тогтоолоор “Мэдээллийн төв сангийн журам”, “Мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах журам болон эх мэдээний дэлгэрэнгүй жагсаалт”-ыг баталсан;
- БОАЖЯ “Геомэдээллийн төв” төсөлтэй хамтран БОС-ын (хуучнаар) статистик мэдээлэл боловсруулах програмыг нэвтрүүлэх ажлыг төлөвлөсөн ч мэдээллийг бүрэн оруулаагүй, нэгдсэн дүнг харах боломжгүй байгаа;
- 2008-2009 онд ан амьтны аймгийн болон байгаль орчинд гарах байгаль орчны төлөв байдлын өөрчлөлт, үнэлгээ, түүний дотор нэн ховор, ховор амьтны тархалт, нягтшил, тоо толгойн өнөөгийн байдал, шинжлэх ухааны байгууллагын мэдээллийг бүрэн бүрдүүлээгүй байгаатай холбоотой байна.

2.76 БОХТХ-ийн 10 дугаар зүйлд 1-д “Байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээнд байгаль орчны төлөв байдал, түүний хувьсал өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, илэрсэн сөрөг өөрчлөлтийг зогсоох, арилгах арга хэмжээ боловсруулах үйл ажиллагаа хамаарна” гэж заажээ.

2.77 Үүний дагуу уг ажлыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан боловч хэрэгжилт удаашралтай байгаагаас байгаль орчинд гарах биологийн хувьсал өөрчлөлт, байгаль орчны төлөв байдлын өөрчлөлтийг тогтоох, үнэлгээ өгөх, түүний дотор нэн ховор, ховор амьтны тархалт, нягтшил, тоо толгойн өнөөгийн байдал, ашиглалт, хамгаалалтын талаархи мэдээллийг олон нийтийн хүртээл болгох ажил хангалтгүй байна.

2.78 Нэн ховор, ховор амьтны хамгаалалтын байдлыг шалгасан ихэнх аймагт мэдээллийн сан бүрдээгүй байна. Тухайлбал,

- Баян-Өлгий аймгийн хэмжээнд 1999-2005 онуудад аргаль, янгирын талаар тохиолдлын чанартай мэдээлэл цуглуулагдаж байснаас өөр судалгаа хийж байгаагүй бөгөөд 2009 онд нөөцийн судалгааг хийж аргаль 1208, янгир 3780 байна гэж тогтоосон;
- Баянхонгор аймагт 1943 онд 300 орчим, 1982 онд 500-800 толгой хавтгай байна гэсэн судалгаа байдаг бөгөөд 1997 онд 100 км² газарт 5 бодьгаль ногдох дундаж нягтшилыг тодорхойлсон ба 2004-2005 онд нэгдсэн аргачлалаар улирал тутам хийсэн тооллого судалгаагаар Алтай Өвөр говийн 29.0 мянган км² талбайд 463+-92 хавтгай байна гэж тогтоосон боловч мэдээллийг санд оруулах ажил хийгдээгүй;
- Дорнод аймагт нэн ховор, ховор амьтны талаар мэдээллийн нэгдсэн сан байхгүй, энэ чиглэлээр судалгаа шинжилгээний ажил, төсөл хөтөлбөр сүүлийн жилүүдэд огт хэрэгжүүлээгүй;
- Говь-Алтай, Дорноговь, Төв, Завхан, Өмнөговь, Төв, Сэлэнгэ аймгуудын БОАЖГ нэн ховор, ховор амьтны нөөцийн болон байршлын судалгаа хийж мэдээллийн сан бүрдүүлээгүй байна.

2.79 Энэ байдлаас үзэхэд БОАЖЯ болон аймаг, орон нутагт нэн ховор, ховор амьтны ан агнуурын болон биологийн төрөл зүйлийн нөөц, байршлын талаархи мэдээллийн сан бүрдээгүй нь холбогдох байгууллагуудын ажлын уялдаа, холбоо хангалтгүй байгаатай холбоотой байна.

Нэн ховор, ховор амьтдыг хамгаалахад ард иргэд, ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна

2.80 Улсын хэмжээнд байгаль хамгаалах чиглэлээр 530 гаруй ТББ үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 13 нь ан амьтан хамгаалах чиглэлээр ажиллаж байна.

2.81 Зарим аймаг, орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд багагүй ажил зохион байгуулжээ. Тухайлбал,

- Баян-Өлгий аймагт ан амьтан хамгаалах 16 нөхөрлөлд 899 иргэн хамрагдаж өөрсдийн амьдарч байгаа орчны ан амьтныг хамгаалах, тоо толгойн байршлыг судлах, хууль бус ан агнуурын тухай мэдээлэх;
- Баянхонгор аймгийн төр захиргааны байгууллагаас хавтгай хамгаалах талаар одоогоор хийсэн ажил байхгүй бөгөөд харин хавтгай хамгаалах төрийн бус байгууллага ажиллаж байгаа;
- Мөн Баянхонгор аймагт ан амьтны хамгаалалтыг сурталчлах талаар орон нутгийн радиод захиалгат нэвтрүүлэг явуулах, сурагчдын дунд “Эко” клуб ажиллуулах, орчны бүсийн мэдээллийн төв байгуулан, байгаль хамгаалах талаар хууль сурталчлах, сонин гаргах, баримтат кино DVD хийх ажил зохион байгуулсан;
- Дорнод аймагт байгаль хамгаалах тухай хууль сурталчилгаанд 900 хүнийг хамруулсан;
- Говь-Алтай аймагт “Мазаалай хамгаалах сан”-гаас нутгийн иргэдийг мазаалайг хамгаалах ажилд татан оролцуулж, “Мазаалай” сурагчдын клуб ажиллуулдаг;
- Өмнөговь аймагт ан амьтан хамгаалах 65 нөхөрлөл байгуулагдан ажиллаж байгаа;
- Төв аймагт төслийн хүрээнд идлэг шонхор хамгаалах, өсгөх зорилгоор 2008 оноос Баян, Баянцагаан, Баян-Өнжүүл сумдад тус бүрт нь 250 ширхэг хиймэл үүрийг байгуулсан;
- Ирвэс хамгаалах сангаас “Ирвэс Энтерпрайз хөтөлбөр”-ийн хүрээнд ирвэс бүхий нутаг дахь малчдын амьжиргаа, тэдний байгаль хамгаалах оролцоог дээшлүүлэх зорилгоор Өмнөговь, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Өвөрхангай, Баянхонгор зэрэг 7 аймгийн 16 сумын 400 гаруй малчин өрх 29 нөхөрлөлд нэгдэн ажиллаж байна.

2.82 Хэдийгээр зарим аймаг, орон нутагт төсөл хөтөлбөрийн хүрээнд нилээд ажил хийгдсэн боловч нутгийн иргэдэд угалз агнуураас тодорхой хувь хэмжээ оногддоггүй учир хамгаалах гэхээсээ илүү ашиг олох сонирхол давамгайлж байна.

2.83 БОАЖС-ын 2006 оны 118 дугаар тушаалаар мазаалайг хамгаалах өсгөн үржүүлэх төлөвлөгөөний дагуу улсын төсвөөс Говь-Алтай аймагт 100.0 сая төгрөг батлагдсаны дагуу мазаалайг гаршуулан судлах түр байр, судалгааны лаборатори, судлаачдын ажлын байр баригдсан боловч одоо болтол ашиглаагүй байна.

2.84 Монгол орны нэн ховор, ховор амьтдын хамгаалалтын байдалд хийсэн аудитаар 105.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 19.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоожээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. БОАЖЯ-наас нэн ховор, ховор амьтдыг хамгаалах талаар зохион байгуулж буй ажлын үр дүн хангалтгүй байна.
2. Олон улсын конвенцийн хүрээнд хэрэгжүүлж буй зарим хөтөлбөрийн үе шат, санхүүжилтийн асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээ, хүрэх үр дүн тодорхой бус байна.
3. Монгол Улсын “Улаан ном”-д бүртгэгдсэн ан амьтны ангилал Дэлхийн байгаль хамгаалах холбооноос гаргасан “Улаан данс”-ны ангилалтай уялдахгүй байна.
4. “Ан амьтан агнах, барих, зөвшөөрөл олгох журам-ыг бүрэн хэрэгжүүлээгүй, тухайн жилд агнуулах амьтны квотыг тогтоохдоо агнуурын нөөцийг тооцолгүй зөвшөөрөл олгож байна.
5. Ховор амьтдыг агнуулснаас орсон төлбөр хураамжийн орлогоос тэдгээрийн нөөц, байршлыг тогтоох, судалгаа шинжилгээний ажилд хөрөнгө төлөвлөж зарцуулаагүй байна.
6. Ховор ан амьтдын тоо толгой, нөөц, тархалтын талаархи мэдээллийн санг зохих журмын дагуу бүрдүүлээгүй байна.
7. Нэн ховор, ховор амьтдыг хамгаалахад ТББ, нутгийн ард иргэдийн оролцоог нэмэгдүүлж, санхүүгийн талаар дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.
8. Ховор ан амьтан хууль бусаар агнагсдад хариуцлага тооцох эрх зүйн орчин дутмаг, торгууль, экологи-эдийн засгийн үнэлгээ бага байгаа нь хууль бус агналтыг таслан зогсоох хөшүүрэг болохгүй байна.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Ч. РАДНАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26-61-71, Факс: (976-51) 26-62-86,
E-mail: monenv@mail.mn, http://www.mne.mn

2010.12.02 № 114369
танай _____-ны № _____-т

Байгаль орчны аудитын
Тайланд санал өгөх тухай

Монгол орны нэн ховор, ховор амьтдын хамгаалалтын байдалд хийсэн байгаль орчны аудитын тайлантай танилцаад дараахи саналтай байна.

Ерөнхий санал

Тайлбар
1-ийг
үзнэ үү.

1. “Зэрлэг амьтан ургамлын аймгийн ховордсон төрөл зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай” конвенци /CITES/-ийн Үндэсний удирдан зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаа тогтмол биш гэдэгтэй санал нэг байгаа бөгөөд энэ зөвлөл орон тооны бус, зориулсан төсөв хөрөнгө байдаггүйтэй холбоотой, мөн ганц нарийн бичгийн дарга энэ чухал конвенцийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахад учир дутагдалтай тул боловсон хүчний асуудал дээр анхаарах, чадавхийг нэмэгдүүлэх, CITES-ийн зөвшөөрлийн төлбөрөөс орж байгаа орлогыг эргээд энэ конвенцийн хэрэгжилтэнд зарцуулдаг механизмыг бүрдүүлэх, энэ конвенцийн хавсралтыг шинэчлэх талаар зөвлөмжийн хэсэгт оруулж өгөх нь зүйтэй.

Тайлбар
2-ийг
үзнэ үү

2. Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн орлогоос ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, судлахад зориулан зарцуулах ёстой, хуулиар тогтоосон /50 хувь/ хувь хэмжээ нь яагаад хуваарилагддаггүй, хууль нь хэрэгждэггүй явдлыг доорхи байдалтай холбож үзэх талтай.

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай хууль”-ийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2000 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д зааснаар аймгуудад дээрх хуулийн дагуу зарцуулах хувь хэмжээний хүрээнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлоготой тэнцэх бусад орлого болон түүнээс дээш хэмжээний хөрөнгийг Сангийн яам аймаг, нийслэлийн төсвийн тусгай дансанд төвлөрүүлэн аймаг, сумдад байгаль орчныг хамгаалахад зарцуулах ёстой байтал энэ арга хэмжээнд зарцуулж байгаа орон нутгийн төсөв байдаггүй.

D:/2010 on/Alban bichig A4

80994

Хуульд заасны дагуу агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогын 50-иас доошгүй хувийг аймаг, нийслэлийн төсвийн тусгай дансанд төвлөрүүлэн тухайн нөөцийг хамгаалах төлөвлөсөн арга хэмжээнд зарцуулах эрх аймаг, нийслэлийн Засаг даргад байгаа боловч тухайн зориулалтаар зарцуулдаггүй байна.

Мөн уг хуулийн 4.2-т заасны дагуу төлбөрийн орлогын зохих хувийг үндсэн чиглэлд газар, ус, ойн нөөцийг хамгаалах арга хэмжээнд улсын төсвөөс нэгдсэн журмаар зарцуулахаар заасан. “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 12.1-д дээрх заалтын дагуу зарцуулах хөрөнгийг Байгаль хамгаалах сангийн эх үүсвэр байхаар заасан атлаа Байгаль хамгаалах санд энэ хөрөнгийг төлөвлөж оруулдаггүй байна. Байгаль хамгаалах сангийн эх үүсвэрийг хуулийн дагуу төвлөрүүлж зарцуулах сайдын эрх үүргийг төсвийн зардлын нэг ангилал болгож Сангийн яамнаас төлөвлөдөг байна.

Тайлбар 3-ыг үзнэ үү

3. 2009 онд нэн ховор амьтан болох хулан адуу, цоохор ирвэс, ховор амьтан болох аргаль хонь, янгир ямаа, хар сүүлт зээр, 2010 онд нэн ховор амьтан болох баданга хүдэр, цаа буга, ховор амьтан болох халиун буга зэрэг амьтдын тархац, нөөцийн судалгааг Монгол орон даяар явуулсан байгаа. Мөн 2010 онд идлэг шонхор болон ховор шувуудын тархац нөөцийн судалгааг хийлгэсэн. 2010 онд хийгдсэн судалгааны дүн тайлан мэдээ хараахан гараагүй байсан нь энэ талаар ажил хийгдээгүй мэт ойлголт төрүүлэхээр байна.

2009 оны судалгаагаар Монгол оронд 14015 толгой хулан адуу, 4 аймгийн 49 сумын нутагт 809 толгой цоохор ирвэс, 2361 толгой бөхөн, 18140 аргаль хонь, 11978 толгой хар сүүлт, 36018 толгой янгир ямаа байна гэсэн дүн гарчээ. 2010 онд идлэг шонхор болон ховор шувуудын тархац нөөцийн судалгаагаар монгол оронд 6835 толгой идлэг шонхор шувуу байгаа тэмдэглэн нийт 52 зүйлийн нэн ховор, ховор шувуудын тархац нутгийг тэмдэглэсэн байна.

2010 оны 11 дүгээр сарын 24-ны байдлаар нэн ховор амьтан болох баданга хүдэр, цаа буга, ховор амьтан болох халиун буга зэрэг амьтдын тархац, нөөцийн хээрийн судалгааг 14 аймгийн нутгийг хамруулан хийж дуусгасан бөгөөд мэдээлэл боловсруулж, үр дүнг гаргах ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байна. Цаашид экосистемийн шүхэр зүйл болох нэн ховор, ховор амьтны судалгааг хөгжлийн төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагаатай уялдуулан хийх шаардлагатай.

Тайлбар 4-ийг үзнэ үү.

4. “Ан агнуурын тухай хууль”-ийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэхь заалтыг хэрэгжүүлэх ялангуяа агналтанд өртөж байгаа амьтны тархац нөөцийг тогтоох, агнуур зохион байгуулалтын ажлыг тогтмол явуулж байх, үүнд зориулсан төсөв, хөрөнгийг бүрдүүлэх талаар аймаг, орон нутгийн түвшинд хангалтгүй ажилладаг байна.

Тайлангийн дүгнэлт хэсэгтэй холбогдуулан өгөх санал

Тайлбар 5-ыг үзнэ үү.

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас нэн ховор ховор амьтдыг хамгаалахаар зохион байгуулж байгаа ажлын үр дүн хангалтгүй байгаа нь НҮБ-ын байгаль орчны суурь 3 конвенцийн нэг болох “Биологийн олон янз байдлын конвенц”-ийн хэрэгжилтийг хариуцсан боловсон хүчний хүрэлцээ мүү, улсын болон орон нутгийн төсвөөс нэн ховор, ховор амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, судлан шинжлэхэд шаардлагатай зардал төсөв маш бага хуваарилагддаг, байгалийн нөөц баялаг ашигласны орлогоос байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай хууль дээд түвшинд хэрэгждэггүйтэй холбоотой байна гэсэн дүгнэлтийг оруулах

Тайлбар 6-г
үзнэ үү.

Тайлбар 7-г
үзнэ үү

2. Зохих хуулийн зохицуулалт байхгүйгээс ан амьтны мэдээллийн сангийн бүрдүүлэлт хангалтгүй удааширалтай явагдаж ирсэн байна.

3. Нэн ховор, ховор ан амьтныг хууль бусаар агнахад тооцох хариуцлага сул, эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байгаа нь хяналтын тогтолцоо буруу, амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ доогуур, бүрэн тогтоогдоогүй байгаатай холбоотой байна.

Хүндэтгэсэн,

САЙД



Л.ГАНСҮХ

Тайлбар

Тайлбар 1	Саналыг хүлээн авах боломжгүй
Тайлбар 2	Энэ талаар тайлангийн зөвлөмжид өмнө нь тусгагдсан учраас нэмэлт оруулах шаардлагагүй.
Тайлбар 3	Тайлангийн хоёрдугаар бүлэгт уг асуудлын талаар тодорхой дурьдсан тул саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар 4	Санал болгосон асуудал тайлангийн нэгдүгээр бүлэгт тусгагдсан байгаа учраас нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй.
Тайлбар 5	Саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар 6	Саналыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар 7	Энэ асуудал аудитын тайлан болон дүгнэлтэд тусгагдсан учир өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхэд зөвлөж байна. Үүнд:

1. БОАЖЯ-наас нэн ховор, ховор амьтныг хамгаалах, зүй зохистой ашиглах, олон улсын конвенцийг хэрэгжүүлэхэд боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх;
2. Монгол орны “Улаан ном”-д орж байгаа амьтдын ангиллыг дэлхийн “Улаан данс-ны ангилалтай уялдуулж, мэдээллийг шинэчлэн хэвлүүлэх;
3. Ховор амьтны агнуурын нөөцийг улсын хэмжээнд бүрэн тогтоох хүртэл ан агнуурын зөвшөөрөл олгох асуудлыг тодорхой хугацаанд хориглох;
4. Гадаадын иргэнээр ан амьтан агнуулах, бариулахаар гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагад тавих хяналтыг сайжруулах;
5. Ховор амьтдыг агнуулсны орлогоос болон төсвөөс тэдгээрийг хамгаалах, нөөц, байршлыг тогтоох, судалгаа шинжилгээний ажилд хүрэлцэхүйц хөрөнгө зарцуулж, үр дүнг тооцохын зэрэгцээ ялангуяа байгаль цаг уур хүндэрсэн (ган, зуд г.м) үед тахь, аргаль, янгир, мазаалай болон бусад ховор амьтдад биотехникийн арга хэмжээнд зориулан хөрөнгө төсөвт төлөвлөж, зарцуулах;
6. Ховор ан амьтны нөөц, тархалт, байршил, тоо толгойг жил бүр аймаг, орон нутгийн мэргэжилтнүүдийн хүчийг ашиглан тогтоож, тайлан мэдээг нэгтгэх, экологи-эдийн засгийн үнэлгээг шинэчлэх, мэдээллийн нэгдсэн санг зохиох журмын дагуу бүрдүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах;
7. Орон нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг төлөвлөн, нэн ховор, ховор амьтдыг хамгаалах талаар тодорхой ажил зохион байгуулах;
8. Ховор амьтан хамгаалах болон хууль бус агнуурыг таслан зогсоох талаар холбогдох хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээ авах.

Нэн ховор, ховор амьтдын талаарх судалгаа

№	Нэн ховор, ховор амьтан	Байршил	Биологийн нөөц (толгой)
Нэн ховор амьтан			
1	Цөөвөр чоно	Өмнөговь, Говь-Алтай аймаг, Алтайн цаад говьд тэмдэглэгдсэн	Устсан тооцсон
2	Цоохор ирвэс	Ховд, Увс, Баян-Өлгий, Завхан, Хөвсгөл, Өмнөговь, Говь-Алтай аймаг, Баянхонгор аймгийн өндөр уулсаар тархсан	700-809
3	Голын халиу	Ховд, Дорнод, Хөвсгөл, Хэнтий аймаг	Мэдээ байхгүй
4	Мазаалай	Говь-Алтай, Баянхонгор аймгийн өмнөд хэсгийн говийн бүсэд	25-40
5	Тахь	Говь-Алтай, Завхан, Төв аймаг	370-500
6	Хавтгай	Говь-Алтай, Баянхонгор аймгийн өмнөд хэсгийн говийн бүсэд	440-490
7	Хүдэр	Увс, Хөвсгөл, Хэнтий, Төв, Сэлэнгэ, Архангай аймаг	
8	Цаа буга	Хөвсгөл аймаг	500-700 орчим
9	Шивэр хандгай	Хөвсгөл, Хэнтий, Төв, Булган, Дорнод аймаг	3000 орчим.
10	Соргог бөхөн	Ховд, Говь-Алтай аймаг, Зүүн гарын говьд тэмдэглэгдсэн	Мэдээ байхгүй
11	Монгол бөхөн	Говь-Алтай, Ховд аймаг	2361
12	Төв Азийн минж	Ховд аймаг	200 орчим
13	Гангар хун	Алтайн өвөр говь, Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөл, Хянган, Дорнод Монголын нуур, гол, мөрөнд нүүдэллэн ирдэг	Монголд 2000 орчим бүл өндөглөдөг.
14	Гургуул	Дорнод аймгийн Их хянганы салбар уулс, Буйр нуурын эрэг болон Гүү азарга, Халх, Шинэ, Эмнэгтийн голууд, Хүйтэн, Авдрантын булгийн зэгс, Увс аймгийн Бөхмөрөн, Ховд голын шугуй, Зэргийн хөндий, Айрхан нуурын хөндийгээр тохиолддог	Мэдээ байхгүй
15	Хар тогоруу	Тарь, Хайчийн цагаан, Орхон гол, Өгий, Улз, Хурх, Хэрлэн, Шуусын гол, Улаанбаатар орчим нүүдлийн үедээ болон зусч буй байдлаар тааралддаг	
16	Цэн тогоруу	Хэнтий аймгийн Онон, Улз, Хэрлэн, Дорнод аймгийн Халх, Нөмрөг голын савд өндөглөн зусдаг. Нүүдлийн үедээ Булган аймгийн Дашинчилэнгийн Баяннуур, Хар бухын гол, Айрхан нуур, Дархадын хотгор, Увс, Хар-Ус нуурт цөөн тоогоор тааралддаг	Мэдээ байхгүй
17	Цагаан тогоруу	Дорнод аймгийн Тарь, Хайчийн цагаан, Архангай аймгийн Өгий нуур, Хэнтий аймгийн Улз, Хурх, Буурь Төв аймгийн Бөөрөлжүүдийн рашаан, Бүхэгийн голд, Завхан аймгийн Тэлмэн нуурт нүүдлийн үедээ болон зусч буй байдлаар тааралддаг	Мэдээ байхгүй
18	Жороо тоодог	Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Алтайн өвөр, Номин, Галбын говиудаар тааралдана. Тархацын зүүн зах Дорноговь аймгийн Цагаан элс, баруунаа Алтайн өвөр говь, Монгол, Говийн Алтайн уулсын ар, Хангайн нурууны өврөөс Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Ачит нуурын хотгор, хойшоо Увсын Давст, Малчин сумын нутаг хүртэл цөл, цөлөрхөг хээр, уулсын хөндий даган далайн төвшнөөс дээш 2700 м хүртэл өргөгдсөн нутагт тааралддаг	Мэдээ байхгүй

19	Борцгор хотон	Хар-Ус, Хар, Хяргас, Увс, Хүнгүйн хар, Бөөнцагаан, Орог, Холбоож, Таацийн цагаан, Өгий нуурт нүүдлийн ба зусч буй үедээ тааралдана. 1950-60-аад оны үед бараг бүх нуурт өндөглөн зусаж байсан бол одоо зөвхөн Хар ус, Айраг нуурт зарим жилд цөөн өндөглөдөг	Мэдээ байхгүй
20	Реликт цахлай	Ховдын Булган гол, Мөнх хайрханы Хөх, Ихэс, Бөөн цагаан, Орог, Таацийн, Лаг, Буйр, Хөх, Тарь, Бүс нуурт тааралдаж байсан.ОХУ, Монголын хил дамнан оршдог Тарь нуур, Дорнод, Сүхбаатар аймгийн хил дээр орших Лаг нуурт өндөглөдөг.	Мэдээ байхгүй
21	Шивэр хилим	Сэлэнгэ, Орхон голд тархсан.	Мэдээ байхгүй
22	Хар мөрний хилим	Онон, Балж голд тэмдэглэгдсэн.	Устсан байж болзошгүй
23	Үхэрдэй	Ховд аймаг. Булган гол.	Мэдээ байхгүй
24	Зантахай загас	Онон, Балж гол тархсан.	Мэдээ байхгүй
25	Бага тогосон одот эрвээхэй		Мэдээ байхгүй
Ховор амьтан			
1	Аргаль хонь	Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 47898 км квадрат нутагт	18140
2	Янгир ямаа	Монгол ба Говийн Алтай, Алтайнөвөр говийн уулс, Увс, Өмнөговь, Хангай, Тагна, Хөвсгөл орчмын уулсаар	36000
3	Хулан адуу	Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Өмнөговь, Ховд аймгийн 177563 км квадрат нутагт	14000
4	Харсүүлтий	Алтайн өвөр говь, Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Өмнөговь, Дорноговь аймаг	12000
5	Халиун буга	Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дорнод, Завхан, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн 102671 км квадрат нутагт	7520
6	Зэгэсний гахай	Монгол Алтайн баруун хойт хэсэг, Их нууруудын хотгор, Алтайн өвөр говийн нуур, голын зэгсэн шугуйд	Мэдээ байхгүй
7	Говийн шилүүс	Тайга, ойт хээр, уулын хээр, цолийн бүсэд	Мэдээ байхгүй
8	Хадны суусар	Хөвсгөл, Хангай, Алтай, Говийн Алтайн уулсаар	Мэдээ байхгүй
9	Цоохондой	Монгол орны Алтайн өвөр говь, Өмнөговь, Дорноговийн өмнөд хэсэгт	Мэдээ байхгүй
10	Эрээн хүрэн	Монгол орны говь, хуурай хээр, цөлийн бүсэд	Мэдээ байхгүй
11	Ойн булга	Хэнтий, Хөвсгөл, Соёон, Алтайн /Булган голын эх/ ой, тайгад, хад, асга бүхий нутагт	Мэдээ байхгүй
12	Гозоорой зурам	Говийн алтайн Гурван сайхан, Арц богд, Их бага богд уулсаар 3200 м өндөр хүртэл нутагт	Мэдээ байхгүй
13	Хүрэн баавгай	Хэнтий, Хөвсгөл, Монгол Алтайн баруун хойт хэсэг, умарт хангай /Хангайн нуруунаас хойш/, Их хянганы салбар уулсын ойт нутагт	Мэдээ байхгүй
14	Алтайн хойлог		Мэдээ байхгүй
15	Хээрийн галуу	110 дугаар уртрагаас баруун зүгийн уулын ойт хээр, тагийн бүслүүрийн нуураар байршина. Хянганы Халх, Нөмрөгт сүүлийн үед үзэгдэхээ байжээ.	Мэдээ байхгүй
16	Махин галуу	Булган,Бөхмөрөн, Ховд, Завхан голын адаг, Ачит, Үүрэг, Увс, Хар ус, Хар, Зэргийн цагаан нуур, Нууруудын хөндийн орог, Бөөнцагаан, Хангайн Өгий, Тэрхийн цагаан, Тэлмэн, Ойгон нуур, Хараа, Буурын гол, Онон, Улз, Хэрлэн, Халх голын саваар өндөглөж, зусна.	Мэдээ байхгүй

17	Халзан ангир	Монголын дорнод хэсэг, Хянган, Монгол Дагуурын нуур голын хөндий, татам, булан, тохой, зэгстэй газар үүрлэж, амьдарна	Мэдээ байхгүй
18	Байгалийн нугас	Буйр нуур, Халх, Нөмрөг, Онон, Улз, Хэрлэн голын савд ховор, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөлд нэн ховор тохиолдоно	Мэдээ байхгүй
19	Хуруут хун	Увс, Бөөн цагаан, Орог, Улаан нуур, Ховд голд тааралддаг.	Мэдээ байхгүй
20	Гунгар хун		Мэдээ байхгүй
21	Ухаа шумбуур	Ойт хээрийн бүслүүрт байршина. Ачит, Орог, Ойгон, Буйр нуур, Булган, Улз, Барх, Хэрлэн, Шанх, Цэнхэрийн гол, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн ойн захад тохиолдоно.	Мэдээ байхгүй
22	Ямаан сүүлт	Их нууруудын хотгорын Увс, Хяргас нуур, Ховдын Зэргийн нуур, Айраг нуурын шигүү зэгстэй эрэг, арал, гүн устай газар идэжлэнэ.	Мэдээ байхгүй
23	Цасч дэглий	Увс, Хяргас, Хар ус, Хар нуурт зусах юм уу нүүдэллэн дайрах үедээ цөөн тоогоор тохиолдоно.	Мэдээ байхгүй
24	Халбаган хошуут	Увс, Хар ус, Хар, Хяргас, Өгий, Буйр, Тэлмэн, Ачит, Толбо, Тэрхийн цагаан нуур зэрэг нуур, Орхон, Сэлэнгэ, Туул, Онон, Завхан, Таац, Тэс, Халх голын зэгстэй намаг, бургасан шугуй, нимгэн устай газар идэжлэнэ	Мэдээ байхгүй
25	Хар өрөвтас	Ойт хээрийн бүслүүрт байршина. Ачит, Орог, Ойгон, Буйр нуур, Булган, Улз, Барх, Хэрлэн, Шанх, Цэнхэрийн гол, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн ойн захад тохиолдоно	Мэдээ байхгүй
26	Хонин тоодог	Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Төв, Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Завхан, Увс аймгийн зэлүүд талд маш цөөн тоогоор үзэгдсэн байна	Мэдээ байхгүй
27	Азийн цууцал	Нууруудын хөндий, Их нууруудын хотгор, Хөвсгөл, Хэнтий, Орхон Сэлэнгийн сав, Монгол дагуур, Хянганы нутгаар нүүдэллэх, өндөглөн зусах байдлаар тааралдана	Мэдээ байхгүй
28	Цагаан амар, Давх	Буйр нуурт	Мэдээ байхгүй
29	Тул	Сэлэнгэ, Дэлгэр мөрөн, Идэр, Орхон, Ерөө, Туул, Чулуут, Суман, Онон, Хэрлэн, Халх гол, Буйр, Өгий, Тэрхийн цагаан, Дархадын хотгорын нууруудад	Мэдээ байхгүй



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2010 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 117

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Монгол орны нэн ховор, ховор амьтдын хамгаалалтын байдал"-д хийсэн байгаль орчны аудитын тайланг баталсугай.

Хоёр. Аудитын тайланг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хорооны дарга Б.Батбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх нарт хүргүүлсүгэй.

Гурав. Аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2011 оны 7 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхэд зөвлөсүгэй.

Дөрөв. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Ганбилэгт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Ч.РАДНАА

070953
tushaal